БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 05 өдөр Дугаар А/141 Баянбулаг

Сумын төрийн байгууллагуудын төрийн албан хаагчдын өдөрлөг, зөвлөгөөн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1,Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 8.1.2, Сумын 2023 оны нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4.1.70, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төрийн байгууллагуудын төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга бат, ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын уялдаа холбоо, үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд төлөвлөж буй зөвлөгөөнийг 2023 оны 05 дугаар сарын 13-аас 14-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Тус зөвлөгөөнийг зохион байгуулах ажлыг хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: М.Чинбат (Тамгын газрын дарга)
Гишүүд: Б.Төгөлдөр (Соёлын төвийн эрхлэгч)
Б.Дажидмаа (Эрүүл мэндийн төвийн эрхлэгч)
Ж.Гантулга (Цаг уур ертөөний дарга)
Г.Түмэнболд (Нягтлан бодогч)
Д.Хандармаа (Операторын ажилтан)
Г.Цэрэндулмаа (Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн)
А.Хангал-Эрдэнэ (Орон нутгийн сан хариуцсан нягтлан)
П.Эрдэнэчимэг (нягтлан бодогч)
А.Амарцэцэг (Математикийн багш)
Э.Цэрэнжав (Дуу хөгжмийн багш)
Ш.Батболд (1 дүгээр багийн засаг дарга)
Ц.Төгссайхан (Биологийн багш)
Ж.Уламбадрах (2 дугаар багийн Засаг дарга)
Г.Дэдбаяр (Төслийн идэвхжүүлэгч)
Б.Буянхишиг (Англи хэлний багш)
Г.Өлзий-Орших (5 дугаар багийн Засаг дарга)

3.Тус зөвлөгөөнд төрийн албан хаагчдыг бүрэн хамруулахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

642301075

4.Зөвлөгөөний хүрээнд гарах хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

5.Зөвлөгөөнд зарцуулагдах зардлыг орон нутгийн нөөц хөрөнгө болон байгууллагын төсөв, бусад эх үүсвэрээс гаргахыг байгууллагын дарга, эрхлэгч, захирал, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА Н.ГАНСҮХ

Баянцагаан сумын Засаг даргын
2023 оны 05 дугаар сарын 05-ны
өдрийн А441 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

УДИРДАМЖ

"Төрийн албан хаагчдын "Есөн эрдэнэ" нэгдсэн
зөвлөгөөн зохион байгуулах тухай"

Зорилго:Салбар хоорондын хамтын ажиллагаа, уялдааг дэмжих замаар төрийн албан хаагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

Хамрах хүрээ:Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Цаг уур өртөө, Цагдаагийн хэсэг, Онцгойн бүлэг.

Хугацаа: 2023 оны 05 дугаар сарын 13-14-ний өдөр

Явагдах төрөл: Сургалт зөвлөгөөн, спорт, урлагийн арга хэмжээ

Сургалт зөвлөгөөн:

- Сумын бодлого, төлөвлөлт
- Төрийн албан хаагчдын ёс зүйн манлайлал
- Архив, албан хэрэг хөтлөлт
- 2022 онд суманд зохион байгуулагдсан хяналт, үнэлгээний талаар, цаашид анхаарах зүйлс
- Төрийн албан хаагчдын санал хүсэлт сонсох

Спортын төрөл:

- Холимог волейболын тэмцээн (Эрэгтэй 2, эмэгтэй 4 хүний бүрэлдэхүүнтэй)
- Дартс (Эрэгтэй 2, эмэгтэй 2)
- Хөгжөөнт буухиа (Нийт 8 гишүүн оролцох ба эрэгтэй 4 хүртэлх байна)
- Шагай шүүрэх (Эрэгтэй 2, эмэгтэй 2)
- Бөхийн барилдаан (36 наснаас дээш, 35 наснаас доош 2 насны ангиллаар явагдаж, ангилал тус бүрд багаас 1 хүн оролцоно)

Урлагийн төрөл:

- Багийн мэндчилгээ (Оролцоог харгалзана)
- Дүрийн жүжигчилсэн тоглолт (Сугалсан сэдвийн хүрээнд 10 минутанд жүжигчилсэн тоглолтыг үзүүлнэ)

Шалгаруулах журам:

- Төрөл тус бүр дээр бага онооны системээр дүгнэж байр эзлүүлнэ.

- ❖ Багуудын ирцийн бүртгэл, оролцоог харгалзан нийлбэр оноонд оруулж тооцно.

Шагнал, урамшуулал: Шагналыг сумын үйлдвэрчний эвлэлээс санхүүжүүлнэ.

Тэргүүн байр- Өргөмжлөл, 400,000 төгрөг

Дэд байр- Өргөмжлөл, 300,000 төгрөг

Гутгаар байр- Өргөмжлөл, 200,000 төгрөг

4-9 дүгээр байрыг тусгай байраар шалгаруулж баг тус бүрд 85,000 төгрөгийн мөнгөн шагналыг тус тус олгоно.

----------oOo----------

Баянцагаан сумын Засаг даргын
2023 оны 05 дугаар сарын 05-ны
өдрийн А/141 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт

БАЯНЦАГААН СУМЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН "ЕСӨН-ЭРДЭНЭ" НЭГДСЭН ЗӨВЛӨГӨӨНИЙ ХӨТӨЛБӨР

№	Зохион байгуулагдах үйл ажиллагаа	Хугацаа	Хаана	Хариуцах эзэн
1	2	3	4	5
2023 оны 05 дугаар 13-нд				
1	Зөвлөгөөний бүртгэл	08:30-09:00 цагт	Соёлын төв	Г.Цэрэндулмаа Д.Хандармаа
2	Урлагийн номер	09:00-09:10 цагт		Б.Төгөлдөр
3	Нээлтийн үйл ажиллагаа, Төрийн дуулал эгшиглэх	09:10-10:00 цагт		М.Чинбат
4	Шагнал гардуулах			
5	Удирдлагын илтгэл	10:00-10:10 цагт		Б.Намгарренчин
6		10:10-10:20 цагт		Н.Гансүх
7	Орон нутгийн бодлого, төлөвлөлт, оролцоо	10:20-10:40 цагт		Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Т.Норов
8	Цайны завсарлага	10:40-11:00 цагт		П.Эрдэнэчимэг
9	Төрийн албан хаагчийн ёсзүй ба манлайлал	11:00-11:30 цагт		Аймгийн ЗДТГ-ын дарга Д.Энхжаргал
10	Архив албан хэрэг хөтлөлт	11:30-12:30 цагт		Төрийн архивын тасгийн дарга В.Эрдэнэчимэг
11	Өдрийн хоол	12:30-13:30 цагт		Г.Дэдбаяр
12	Зүрх сэтгэлийн боловсрол	13:30-14:50 цагт		МУ-ын гавьяат багш, Доктор Ш.Чимгээ
13	Баянцагаан суманд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүн, цаашид анхаарах зүйлс	14:50-15:20 цагт		Аймгийн ЗДТГ-ын дарга Д.Энхжаргал
14	Оролцогчдын асуулт, хариулт, санал.	15:20-16:00 цагт		М.Чинбат
15	Завсарлага	16:00-16:20 цагт		
16	Бөхийн барилдаан	16:30-17:30 цагт	Спорт заал	Ш.Батболд Г.Өлзий-Орших
17	Хөгжөөнт буухиа	17:30-18:30 цагт		А.Амарцэцэг Ц.Төгссайхан
18	Оройн цэнгүүн	19:00-22:00 цагт	Соёлын төв	Б.Төгөлдөр Б.Буянхишиг
2023 оны 05 дугаар 14-нд				
19	Волейболын тэмцээн	08:00 цагт	Спорт заал	А.Хангал-Эрдэнэ Г.Түмэнболд
20	Дартс	09:00 цагт		Ж.Уламбадрах Г.Цэрэндулмаа
21	Шагай шүүрэх	09:00 цагт		Ж.Гантулга П.Эрдэнэчимэг
22	Урлагийн номер, мэндчилгээ	18:00 цагт	Соёлын төв	Б.Төгөлдөр Э.Цэрэнжав
23	Шагнал гардуулах, Хаалт	22:00 цагт		Ажлын хэсэг

----------oOo----------